

Төгс эзэмших сургаал:

1-р шалгалтын зааварчилгаа

1 НИФАЙ 3:7-ООС МОЗАЯ 18:8-10

Судрын эшлэл, түлхүүр үг хэллэгийг цээжлэх

Төгс эзэмших сургаалын судрын эшлэл, түлхүүр үг хэллэгийг сайн мэддэг бол. Та давтахдаа Doctrinal Mastery гар утасны аппликэйшнийг татаж аван ашиглаж болох юм.

Судрын эшлэл	Судрын түлхүүр үг хэллэг
1 Нифай 3:7	“Би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно.”
2 Нифай 2:25	“Адам хүмүүн байж болохын тулд унасан; мөн тэд баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө.”
2 Нифай 2:27	“Тэд . . . эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгох эсвэл . . . боолчлол болон үхлийг сонгох эрхтэй.”
2 Нифай 26:33	“Бурханд бүгд адил.”
2 Нифай 28:30	Бурхан “Учир нь болгоогтун, би хүмүүний үрст шат шатаар, дүрэм дүрмээр өгөх болно.”
2 Нифай 32:3	“Христийн үгэн дээр найрла, учир нь болгоогтун, Христийн үгс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно.”
2 Нифай 32:8–9	“Та нар үргэлж залбирах ёстой.”
Мозая 2:17	“Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу.”
Мозая 2:41	“Бурханы зарлигуудыг дагадаг тэд . . . бүх зүйлд адислагдсан болой.”
Мозая 3:19	“Эгэл хүмүүнээ орхиж мөн Их Эзэн Христийн цагаатгалаар гэгээнтэн [бол].”
Мозая 4:9	“Бурханд итгэ; . . . Тэр бүх мэргэн ухааныг эзэмшигч гэдэгт итгэ.”
Мозая 18:8–10	“Гэрээ байгуулснаа түүний өмнө гэрчилж, Их Эзэний нэрээр баптисм хүрт.”

Сургаалыг бодит амьдралын нөхцөл байдалд хэрэгжүүлэх

- Амьдралдаа чухал шийдвэр гаргахын өмнө удирдамж заавар авах хэрэгтэй хэн нэгэнд туслахын тулд төгс эзэмших сургаалын судрын нэг эсвэл хэд хэдэн хэсгийг ашигла.

- Өөрийнх нь нөхцөл байдал Бурханы зарлигуудыг дагахад хэцүү болгодог хэмээн боддог хүнд туслахын тулд судрын хэд хэдэн хэсгийг сонго.

- Төгс эзэмших сургаалын судрын аль нэгэн хэсгээс сонгоод, тухайн хэсэгт заасан үнэнүүд өсвөр насны хүүхдийн амьдралд тусалж болох нөхцөл байдлыг бод. Боломжтой бол мэддэг эсвэл өөрт тулгарсан бодит нөхцөл байдлын талаар бод.
-
-

- Төгс эзэмших сургаалын судрын аль аль хэсэг танд хамгийн их нөлөөлсөн талаар хуваалцахад бэлд. Тухайн хэсэг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын талаар танд юу заадаг вэ?
-
-

Сүнслэг мэдлэг олж авах зарчмууд

2023 оны *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материалын* “Сүнслэг мэдлэг олж авах” хэсгийн 5–12-р догол мөрийг давт. Тулгарч буй сорилт бэрхшээл, асуудлыг даван туулахад нь хэн нэгэнд туслахын тулд сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг хэрхэн ашиглаж болохыг тунгаан бод.